

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хан-Уул дүүргийн Хан-Уул зам засвар, арчлалт ОНӨААТҮГ-ийн
2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2026/127/НА-СТА-ОНӨҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Нийслэл дэх төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Г. Нандинжаргал Утас: 7000-7734 Цахим хаяг: nandinjargalg@audit.gov.mn</p> <p>Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер: Х.Түвшинбаяр Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: С.Гантөгс Утас: 325093 Цахим хаяг: gantugss@audit.gov.mn</p> <p>Гэрээгээр гүйцэтгэсэн: Гэрэлт хөхийн тэнцвэр Аудит ХХК-ийн захирал: Д.Баатарсайхан Утас: 9909-9119 Цахим хаяг: gerelthuhaudit@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	Error! Bookmark not defined.
3.1 Компани /ТӨҮГ/, түүний үйл ажиллагаа	Error! Bookmark not defined.
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	Error! Bookmark not defined.
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	Error! Bookmark not defined.
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт	Error! Bookmark not defined.
3.5. Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл.....	Error! Bookmark not defined.
4. АУДИТЫН ТАЙЛАН	Error! Bookmark not defined.
4.1 Ерөнхий зүйл.....	Error! Bookmark not defined.
4.2 Материаллаг байдал	Error! Bookmark not defined.
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	Error! Bookmark not defined.
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	Error! Bookmark not defined.
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .	Error! Bookmark not defined.
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	8
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	14

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НИТХ	Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал
НТАГ	Нийслэл дэх төрийн аудитын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
НӨХГ	Нийслэлийн өмчийн харилцааны газар
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026-05-15 № 890
танай _____-ны № _____-т

ХАН-УУЛ ЗАМ ЗАСВАР АРЧЛАЛТ
ОНӨААТҮГ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Д.ГАНБАДРАХ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хан-Уул дүүргийн Хан-Уул зам засвар, арчлалт ОНӨААТҮГ-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүхий л материаллаг байдлын үүднээс Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв толилуулсан байна

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 12 дугаар тогтоолоор 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд нийт орлогыг 6,851.2 сая төгрөг, нийт зардлыг 6,851.2 сая төгрөг байхаар баталснаас гүйцэтгэлээр 7,205.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 6,985.9 сая төгрөгийн зардал гаргаж 219.3 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд гэр хорооллын гудамж талбайг зохист найрлагат хайргаар Дүүргийн засаг даргын А/293, А/294, А/295, А/504 тоот захирамжуудаар нийт 136,930.3м² талбайг үйл ажиллагааны нийт зардлын 14.4 хувь буюу 1,004.7 сая төгрөгөөр засварласан байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 14 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 90.0 хувийн хэрэгжилттэй гүйцэтгэсэн гэж тайлагнасан байна.

С.Уянгаарга | Дайрх Ерөнхий Аудитор **1426050899**

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	499,192,085.06	1,571,295,532.67
Дансны авлага	33,325,127.00	3,118,506.99
Татвар, НДШ – ийн авлага	292,988,187.39	20,289,916.37
Урьдчилж гарсан зардал	125,461,740.00	26,548,600.00
Бараа материал	255,340,114.82	274,198,295.07
Эргэлтийн хөрөнгийн дүн	1,206,307,254.27	1,895,450,851.14
Эргэлтийн бус хөрөнгө	1,789,976,596.49	1,371,371,664.41
Үндсэн хөрөнгө	1,789,976,596.49	1,371,371,664.41
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,789,976,596.49	1,371,371,664.37
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,996,283,850.76	3,266,822,515.51
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
Өр төлбөр		
Богино хугацаат өр төлбөр		
Татварын өр	-	51,256,831.96
Богино хугацаат өр төлбөрийн дүн	-	51,256,831.96
Өр төлбөрийн нийт дүн	-	51,256,831.96
Эздийн өмч		
Өмч:- төрийн	2,996,283,850.76	3,215,565,683.55
Эздийн өмчийн бусад хэсэг	1,055,003,000.00	1,055,003,000.00
Хуримтлагдсан ашиг	1,941,280,850.76	2,160,562,683.55
Тайлант үеийн үр дүн	(269,028,507.82)	219,281,832.79
Эздийн өмчийн дүн	2,996,283,850.76	3,266,822,515.51
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	2,996,283,850.76	3,266,822,515.51

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Үйл ажиллагааны орлого	13,932,414,636.01	7,205,182,486.47
1.1	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	-	-
	Нийт ашиг (алдагдал)	13,932,414,636.01	7,205,182,486.47
6	Бусад орлого	134,636,444.01	-
7	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
8	Ерөнхий ба удирдлагын зардал	14,201,443,143.83	6,889,511,632.14
	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(246,869,076.17)	243,646,480.88
19	Орлогын татварын зардал	22,159,431.63	24,364,648.09
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(269,028,507.80)	219,281,832.79
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(269,028,507.80)	219,281,832.79
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-

Хан-Уул дүүргийн Зам засвар, арчлалт ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

23.1	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	-	96,389,021.54
24	Орлогын нийт дүн	(269,028,507.82)	219,281,832.79

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	134,636,444.01	7,205,182,486.47
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	134,636,444.01	15,859,406.47
1.1.6	Бусад мөнгөн орлого	13,797,778,192.00	7,189,323,080.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	13,535,682,976.93	6,119,745,238.86
1.2.1	Ажиллагчдад төлсөн	1,839,928,474.99	2,014,937,474.04
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	262,155,011.69	288,014,203.55
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	7,676,272.50	4,314,752.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	61,446,836.76	63,443,043.05
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	235,874,450.00	128,981,536.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	22,159,431.63	1,480,940.64
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	740,175.00	942,030.00
1.2.10	Бусад мөнгөн зарлага	10,971,671,387.36	3,617,631,259.58
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	396,731,659.08	1,085,437,247.61
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	66,742,500.00	13,333,800.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(66,742,500.00)	(13,333,800.00)
4	Валютын ханшийн зөрүү	-	-
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	329,989,159.08	1,072,103,447.61
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	169,202,925.98	499,192,085.06
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	499,192,085.06	1,571,295,532.67

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2023 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	738,735,000.00	-	2,210,309,358.58	2,949,044,358.58

Хан-Уул дүүргийн Зам засвар, арчлалт ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	316,268,000.00	-	-	316,268,000.00
3	Залруулсан үлдэгдэл	1,055,003,000.00	-	2,210,309,358.58	3,265,312,358.58
9	2024 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	1,055,003,000.00	-	1,941,280,850.76	2,996,283,850.76
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	219,281,832.79	219,281,832.79
17	2025 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	1,055,003,000.00	-	2,160,562,683.55	3,215,565,683.55

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт		ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Биелэлт хувь	Зөрүү
1. Нийт орлого		6,851,240,010.00	7,205,182,486.47	105%	(353,942,476.47)
1.1	Дээд шатны байгууллагаас авсан санхүүжилт	6,851,240,010.00	6,851,240,100.00	100.0%	(90)
1.2	Бусад орлого	-	353,942,386.47	-	(353,942,386.47)
2. Нийт зардал		6,851,240,010.00	6,985,900,653.68	101.9%	(134,660,643.68)
2.1	Үндсэн болон нэмэгдэл цалин	2,515,358,810.00	2,017,117,879.26	80%	498,240,930.74
2.2	НД,ЭМДШимтгэлийн зардал	389,879,100.00	288,123,747.70	73.9%	101,755,352.3
2.3	Түрээс ашиглалтын зардал	64,328,300.00	63,443,043.05	98.6%	885,256.95
2.4	Нормын хувцас, зөөлөн эдлэл	17,825,000.00	12,482,800.00	70%	5,342,200.00
2.5	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,000,000.00	3,000,000.00	100%	-
2.6	Шуудан холбооны зардал	5,885,900.00	5,761,378.69	97.8%	124,521.31
2.7	Урсгал засвар	1,547,301,000.00	1,929,358,856.70	124.7%	(382,057,856.7)
2.8	Шатахууны зардал	129,162,500.00	156,601,673.50	121.2%	(27,439,173.5)
2.9	Сургалтын зардал	2,275,000.00	1,190,000.00	52.3%	1,085,000.00
2.10.	Бага үнэтэй түргэн элэгдэх	67,494,100.00	48,695,552.00	72.1%	18,798,548.00
2.11	Хөдөлмөр хамгааллын зардал	11,819,500.00	2,275,000.00	19.2%	9,544,500.00
2.12	Бичиг хэргийн зардал	4,456,100.00	4,332,048.50	97.2%	124,051.5
2.13	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,056,967,000.00	2,006,741,359.50	97.5%	50,225,640.05
2.14	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол		335,549,710.60		(335,548,71.60)
2.15	Даатгалын үйлчилгээ	1,500,000.00	942,030.00	62.8%	557,970.00
2.16	Тээврийн хэрэгслийн татвар	3,200,000.00	3,126,200.00	97.7%	73,800.00
2.17	Тээврийн хэрэгслийн оношлогоо	700,000.00	385,000.00	55%	315,000.00
2.18	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	500,000.00	281,000.00	56.2%	219,000.00
2.19	Орлогын албан татварын зардал		1,480,940.64		(1,480,940.64)
2.2	Бусад зардал	29,587,700.00	8,623,412.00	29.1%	20,964,288.00
2.21	Үндсэн хөрөнгө худалдасны гарз	0,00	96,389,021.54		(96,389,021.54)
3. Цэвэр ашиг, алдагдал		-	219,281,832.34		(219,281,832.34)

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 22,670.7 мянган төгрөгийн зөрчил¹ илэрсэнд 1 албан шаардлага 2 зөвлөмжийг хүргүүлж байна.

Нийт залруулагдаагүй 22,670.7 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг түвшин 68,895.1 мянган төгрөгөөс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

5.1 Албан шаардлага

Бараа материалын дэлгэрэнгүй бүртгэлийг шалгахад тайлант онд ямар нэгэн ажил гүйлгээ, хөдөлгөөн хийгдээгүй 46 нэр төрлийн 333 тоо хэмжээ бүхий 19,570.7 мянган төгрөгийн бараа материал байгаа нь Төрийн хэмнэлтийн хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д “нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хэрэгцээ шаардлагаас их хэмжээний бараа материал нөөцөлсөн зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй ажиллах талаар албан шаардлага өгөх;

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт-1: Авто машины дугуй Техник ашиглалтын паспорт хөтлөлт зөрүүтэй нярвын тайлан болон механик инженерийн үзлэг хугацаа зөрүүтэй 3,100.0 мянган төгрөгийн сэлбэг норм норматив хангаагүй эвдэрсэн шалтгаан тодорхойгүй техникийн паспортад бүртгэл хөтлөлт хангалтгүй зэрэг тодорхойлоогүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээ бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгийн ашиглах хугацаа, нормын дагуу элэгдлийн тооцоололд тавих дотоод хяналтыг сайжруулж, анхан шатны баримтын бүрдлийг ханган ажиллах;

2. Эд хариуцагчтай холбоотой асуудал

Илрүүлэлт-2: Эд хариуцагчийн картанд хөрөнгийн хөдөлгөөнийг тухай бүр шинэчилж хөтлөөгүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйл. 2/ "бараа, материал, үнэ бүхий зүйлийн орлого, зарлагыг цэгцлэн шалгаж, нэр төрлийн бүртгэлийг эд хариуцагч бүрээр хөтлүүлж тайлан гаргуулан үлдэгдлийн

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

бүртгэлтэй тулган шалгасан байх;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар" гэсэн заалттай нийцээгүй байна санхүүгийн тайлагналын "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгийн хөдлөл бүрд эд хариуцагчийн картад баяжилт хийж хэвших;

Дээрх аудитын шийдвэрийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 09 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**6.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Авто машины дугуй Техник ашиглалтын паспорт хөтлөлт зөрүүтэй нярвын тайлан болон механик инженерийн үзлэг хугацаа зөрүүтэй уг сэлбэг норм норматив хангаагүй эвдэрсэн шалтгаан тодорхойгүй техникийн паспортад бүртгэл хөтлөлт хангалтгүй байна..	1	3,100.0					1	3,100.0
Эд хариуцагчийн картанд хөрөнгийн хөдөлгөөнийг тухай бүр шинэчилж хөтлөөгүйгээс хөрөнгө солигдох эрсдэлтэй байна.	1	-					1	-
Бараа материалын дэлгэрэнгүй бүртгэлийг шалгахад тайлант онд ямар нэгэн ажил гүйлгээ, хөдөлгөөн хийгдээгүй 46 нэр төрлийн 333 тоо хэмжээ бүхий 19,570,700.00 төгрөгийн бараа материал байна.	1	19,570.7			1	19,570.70		
Дүн	3	22,670.7			1	19,570.7	2	3,100.0



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 05 сарын 15 өдөр

Дугаар 554/11810519

Улаанбаатар хот

НТАГ-2026/127/НА-СТА-ОНӨУГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хан-Уул дүүргийн Зам засвар, арчлалт ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд ямар нэгэн ажил гүйлгээ, хөдөлгөөн хийгдээгүй 46 нэр төрлийн 333 тоо хэмжээ бүхий 19,570,700.00 /арван есөн сая таван зуун далан мянга долоон зуун / төгрөгийн бараа материал худалдан авч нөөцөлсөн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-д "Нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.4-д "төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан, зах зээлийн үнээс өндөр үнэтэй эсвэл шаардлагагүй хөрөнгө олж бэлтгэсэн" заалтад заасныг үндэслэн ШААРДАХ нь:

1. Хэрэгцээ шаардлагаас илүү их хэмжээний бараа материал нөөцөлсөн зөрчлийг зогсоож, давтан гаргахгүй ажиллах, биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хан-Уул дүүргийн Зам засвар, арчлалт ОНӨААТҮГ-ын дарга Д.Ганбадрах, нягтлан бодогч Д.Нямлхагва нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ГЭРЭЛТ ХӨХИЙН ТЭНЦВЭР
АУДИТ ХХК ЗАХИРАЛ

Г.НАНДИНЖАРГАЛ
С.ГАНТӨГС

Д.БААТАРСАЙХАН

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө,
Г корпус, 5 давхар

1426091013